

ТАНИЛЦУУЛГА

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДЭЭС ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗАРТ ДӨРӨВДҮГЭЭР УЛИРАЛД ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

2020.12.20

Сангийндалай

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд иргэдээс бичгээр 377 иргэнээс ирүүлсэн 377 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тавих дотоодын хяналтыг сайжруулж хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан ил тод байдлыг илтгэх үзүүлэлтийн дагуу ЗДТГ нь СӨГ хүлээн авч шийдвэрлэхэд 70595501, 88210582 утаснуудад хүлээн авч ажиллаж байна. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд ирүүлсэн СӨГ-ийг СӨГ бүртгэх дэвтэрт бүртгэн хяналтын карт хөтлөн холбогдох албан тушаалтанд өгч шийдвэрлүүлж хариуг эзэнд нь утсаар болон албан тоотоор хүргэж ажиллаж байна.

Иргэдийн өргөдөл, гомдол түүнд тусгагдсан асуудал шийдвэрлэсэн байдал.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан нийт 377 өргөдлийг 100 хувийн биелэлттэй байна.

Иргэдээс ирсэн санал өргөдөл гомдлыг байгууллага бүрээр, өргөдөл гомдлын утга агуулга бүрээр авч үзвэл:

ЗДТГ: Санхүүгийн дэмжлэг хүссэн 1 иргэний өргөдөл ирснийг ЗДЗ-ын хурлаар хэлэлцэн Засаг даргын Тамгын газрын орон нутгийн нөөц хөрөнгөөс зарцуулахаар хуралд оролцсон гишүүдийн 100% саналаар дэмжиж шийдвэрлэв. 300.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, Тамхины зөвшөөрөл авах хүсэлтийг иргэн Отгон ирүүлснийг Сумын засаг даргын 2020 оны 11 сарын 30 ны өдрийн А/94 тоот захирамжаар тамхины тусгай зөвшөөрлийг олгосон. Мөн Бодьсог хангай ХХК нь тамхины тусгай зөвшөөрөл нь 2020 оны 12 сарын 20 нд дуусах байсныг сунгах хүсэлт ирүүлсний дагуу 2020 оны 11 сарын 30 ны өдрийн А/95 тоот захирамжаар тамхины тусгай зөвшөөрлийг 3 жилээр сунгаж шийдвэрлэсэн. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдах 2 хүсэлт гаргасныг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 2 иргэн эргэн

төлөлтийг түр хойшлуулах хүсэлт ирүүлснийг Засаг даргад танилцуулан шийдвэрлүүлэхээр өгсөн. Шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Хүүхдийн цэцэрлэг: Хүүхдээ цэцэрлэгт өгөхийг хүссэн 6 эцэг эхийн өргөдөл ирснийг хүлээн авч шийдвэрлэсэн.

СД-Эмнэлэг: Ажилд орох 1 хүсэлт ирүүлснийг гарсан орон тоо байхгүй тухай хуулийн хугацаанд хариуг мэдэгдсэн.

БД-Сургууль: Ажилд орох хүсэлт 1 ирүүлснийг хуулийн хугацаанд орон тоо байхгүй гэж утсаар мэдэгдсэн.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж хариуцсан мэргэжилтэн: Нийгмийн халамж, даатгал, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой асуудлаар 112, хүүхдийн мөнгөтэй холбоотой 28 өргөдөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудлаар 45, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 8 өргөдөл ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг эзэнд мэдэгдсэн.

Иргэний бүртгэлийн мэргэжилтэнд: Гэрлэлтээ батлуулаагүй эцэг эхээс хүүхдээ төрсөн эцгээр нь батлуулахыг хүссэн 20, Төрсний гэрчилгээг дахин авахыг хүссэн 5, Шинээр гэр бүл болохыг хүссэн 2, шилжилт хөдөлгөөн 18, гэрлэлтийн гэрчилгээ дахин авах 2 өргөдөл ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг эзэнд мэдэгдсэн.

Нийгмийн даатгалын албанд: Тэтгэвэрт орохыг хүссэн 32, нөхөн тооцолт 9, ХЧТА 36, Жирэмсэн Амаржсаны тэтгэмж бодуулахыг хүссэн 45 өргөдөл ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг мэдэгдсэн.

Хүснэгт 1

2020 ОНЫ 4-Р УЛИРАЛД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт
			Шийдвэрлэ ж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	ЗДТГ	7	5	-	-	2	100%
2	Хүүхдийн цэцэрлэг	6	6	-	-	-	100%
3	СДЭмнэлэг	1	1	-	-	-	100%

4	БДСургууль	1	1	-	-	-	100%
5	Соёлын төв	-	-	-	-	-	-
6	Иргэний бүртгэл	47	47	-	-	-	100%
7	Нийгмийн халамж	193	193	-	-	-	100%
8	Нийгмийн даатгал	122	122	-	-	-	100%
НИЙТ ДҮН		377	375	-	-	2	100%

Хүснэгт 2

2020 ОНЫ 4-Р УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ \ХЭЛБЭРЭЭР\

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдол санал хүсэлт	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	ЗДТГ	7	5				
2	Хүүхдийн цэцэрлэг	6	6				
3	СДЭмнэлэг	1	1				
4	БДСургууль	1	1				
5	Соёлын төв	-	-				
6	Иргэний бүртгэл	47	47				
7	Нийгмийн халамж	193	193				
8	Нийгмийн даатгал	122	122				
НИЙТ ДҮН		377	377	-	-	-	-

Хүснэгт 3

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА \ХУВИАР\

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал \тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь\		
		Өргөдөл		Тоо/ Хувь
1.	ЗДТГ	Асуудлын нэр		Нийт тоо Нийт хувь

		Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдах	2	28.5%
		Сум хөгжүүлэх зээл хойшлуулах	2	28.5%
		Санхүүгийн дэмжлэг хүссэн	1	14.3%
		Бусад	2	28,5%
3	СД-Эмнэлэг	Ажилд орох	1	100%
4	БД-Сургууль	Ажилд орох	1	100%
5	Хүүхдийн цэцэрлэг	Цэцэрлэгт хүүхдээ өгөх	6	100%
6	Нийгмийн халамж	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжинд хамрагдах	112	58.3%
		ХБИ-ий асуудлаар	45	23.3%
		хүүхдийн мөнгөтэй холбоотой	28	14.5%
		Бусад	8	4.%
7	Иргэний бүртгэл	Төрсний гэрчилгээ дахин авах /хаяж гээгдүүлсэн /	5	10.6%
		Гэрлэлтээ батлуулаагүй эцэг эхээс хүүхдээ төрсөн эцгээр нь батлуулах	20	42.5%
		Шинээр гэр бүл болох	2	4.4%
		Гэрлэлтийн гэрчилгээ дахин авах	2	4.4%
		Шилжилт хөдөлгөөн	18	38.2%
8	Нийгмийн даатгал	Тэтгэвэрт орохыг хүссэн	32	26.2%

		ХЧТА	36	29.5%
		Жирэмсэн Амаржсаны тэтгэмж бодуулах	45	36.9%
		Бусад	9	7.3%

Тайлан хянасан:

ЗДТГ-ын даргаГ.Энхдэлгэр

Тайлан нэгтгэсэн:

ЗДТГ-ын СӨГХ хариуцсан мэргэжилтэн..... Т.Эрдэнэзаяа /88210582/